



MNS ISO/IEC 17020:2013 стандартад итгэмжлэгдсэн байгууллага
РАДИО ДАВТАМЖ, ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХЯНАЛТЫН ТӨВ



УЛААНБААТАР ХОТЫН РӨН-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДЭД 2025 ОНЫ 8 ДУГААР САРД ХИЙСЭН СУУРИН ХЯНАЛТЫН МЭДЭЭ

Тайлангийн дугаар: Хяналт/2025/15

Хэвлэсэн огноо: 2025.09.02

1. Хэмжилтийн зорилго, хамрах хүрээ:

Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын FM радио нэвтрүүлэх станцад MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг мөрдүүлэх зорилготой.

2. Хэмжилт хийсэн огноо, байршил, зураг:

№	Огноо	Хэмжилт хийсэн хаяг	Байршлын өргөрөг, уртраг
1	2025.08.01 2025.08.29	Улаанбаатар хотын СХД-ийн 34-р хороонд байрлах ХХЗХ-ны РДӨНХТ	47°54'51.50"N 106°45'43.33"E/



Зураг 1. Хэмжилт хийсэн FMS-2020 суурин хяналтын станцын байршил

3. Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:

FMS-2020 суурин хяналтын станц /RmcFX2dm02Mn/


4. Норматив бичиг баримт:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандарт


5. Хэмжилтэд оролцсон бүрэлдэхүүн:

Хэмжилт хийж гүйцэтгэсэн			
№	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Ж.Дөлгөөн	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер
2	М.Чагнаадорж	ХХЗХ	РДӨНХТ-ийн суурин хяналтын инженер

6. Хэмжилт хийх үеийн зураг:




Зураг 2. Радио давтамжийн 88-108 МГц-ийн зурвасын хэмжилт




Зураг 3. Радио давтамжийн 88-108 МГц-ийн зурвасын хэмжилт


7. Хэмжилтийн дүн:



Зураг 4. Зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлтын хэмжилтийн үр дүн



Зураг 5. Хэрэглэх зурвасын өргөний хэмжилтийн үр дүн



Зураг 6. Давтамжийн хазайлтын максимум утгын хэмжилтийн үр дүн

Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамж, өргөн нэвтрүүлгийн хяналтын төв нь радио давтамжийн суурин хяналтыг тогтмол хийдэг. Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 33 хуулийн этгээдийн FM радиогийн нэвтрүүлэх станцуудад 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 29-ний өдрүүдэд суурин хяналтыг хийж гүйцэтгэлээ.

7.1 Стандартын шаардлагыг хангасан:

MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын 5-р зүйлд заасан давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц, нэвтрүүлэгчийн зөөгч давтамжийн зөвшөөрөх хазайлт 2 кГц, хэрэглэх зурвасын өргөн 300 кГц-ээс хэтрэхгүй гэсэн шаардлагыг 24 FM радио станц хангаж үйл ажиллагаа явуулж байгаа нь хэмжилтээр тогтоогдсон.

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22800192	88.3
2	СКОД ХХК	22800167	88.8
3	Сета тех ХХК	22800193	89.3
4	Эх болсон зургаан зүйл НҮТББ	22800186	89.7
5	Манай аялгуу эф эм ар ХХК	22800178	90.5
6	Хэмнэлт долгион медиа групп ХХК	22800147	91.7
7	Смарт коммуникэйшн ХХК	22800158	92.1
8	Тэргүүн медиа ХХК	22800146	92.5
9	Хүүхэд, ирээдүй, соёл, боловсрол сан ТББ	22800097	95.7
10	Автордио эфэм ерэн зургаа аравны гурав ХМХ	22800070	96.3
11	Эх элгэн нутаг ХХК	22800114	96.9
12	Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийд ШБ	22800071	97.5
13	Радиоком Монгол ХХК	22800025	98.1
14	Нью медиа ХХК	22800026	99.3
15	Дижитал радио ХХК	22800060	99.7
16	Агрегатор ХХК	22800022	101.7
17	Эм Эс Жи Эм Эл ХХК	22800175	102.1
18	Бадруун ХХК	22800006	102.5
19	Радио телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	103.1
20	Салхи Энтертейнмент ХХК	22800057	104.5
21	Чугу ХХК	22800037	105.5
22	Радио телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	106.0
23	И Зэт Эф Эм ХХК	22800038	107.0
24	Билэг санаа ХХК	22800018	107.5

7.2 Стандартын шаардлагыг хангаагүй:

MNS 4909:2000 стандартын шаардлагыг хангаагүй буюу давтамжийн хазайлтын максимум утга ± 75 кГц-ээс хэтэрсэн хуулийн этгээдийн мэдээлэл:


№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Шүхэр ТББ	22800117	95.1
2	Радио телевизийн Үндэсний Сүлжээ УТҮГазар	22800044	100.9
3	Медиа холдинг ХХК	22800009	103.6

7.3 Үйл ажиллагаагаа түр зогсоосон:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Монгол комикс ХХК	22800159	91.1
2	Монголиан Мюзик Медиа ХХК	22800024	98.9
3	РФ ХХК	22800005	100.1
4	НС Холбоо ХХК	22800040	100.5
5	Ви Өү Эм ХХК	22800052	104.0
6	Стандарт Ви Оү Эй ХХК	22800001	106.6

Тус хороонд РӨН-ийн үйл ажиллагаагаа түр зогсоосон тухай РӨН-ийн хэт богино долгионы 22800024 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Монголиан Мюзик Медиа ХХК-ийн 98.9 МГц-ийн FM радио станц нь 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн АБ28/0012 тоот албан бичгээр, 22800005 дугаарын тусгай зөвшөөрөлтэй РФ ХХК-ийн 100.1 МГц-ийн FM радио станц нь 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/01 тоот албан бичгээр, 22800052 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Ви Өү Эм ХХК-ийн 104.0 МГц-ийн FM радио станц нь 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 015 тоот албан бичгээр, 22800001 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Стандарт Ви Оү Эй ХХК-ийн 106.6 МГц-ийн FM радио станц нь 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 52 тоот албан бичгээр тус, тус мэдэгдсэн. Харин 22800159 дугаарын тусгай зөвшөөрөлтэй Монгол комикс ХХК-ийн 91.1 МГц-ийн FM радио станц, 22800040 дугаарын тусгай зөвшөөрөлтэй НС Холбоо ХХК-ийн 100.5 МГц-ийн FM радио станцууд нь үйл ажиллагаагаа түр зогсоосон тухай албан бичиг ирүүлээгүй байна.

7.4 Ажиллаж буй дахин дамжуулах станцууд:



Зураг 7. Радио давтамжийн 75 МГц-85 МГц-ийн зурвасын хэмжилт

Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ажиллаж буй хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн дахин дамжуулах станцуудын мэдээлэл:

№	Эзэмшигчийн нэр	Зөвшөөрлийн дугаар	Радио давтамж (МГц)
1	Радио телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22830021	76.1
2	Эм Жи Эл Радио ньюс ХХК	22830001	76.5
3	Чугу ХХК	22830003	76.9
4	Сета тех ХХК	22830002	77.3
5	Манай аялгуу эф эм ар ХХК	22830004	77.7
6	Эх элгэн нутаг ХХК	22830005	78.1
7	СКОД ХХК	22830018	79.3
8	Бадруун ХХК	22830009	80.5
9	Эм Эс Жи Эм Эл ХХК	22830012	82.1
10	Радио телевизийн Үндэсний Сүлжээ УТУГазар	22830019	82.9
11	И Зэт Эф Эм ХХК	22830008	83.3
12	Радиоком Монгол ХХК	22830020	84.1
13	Салхи Энтертейнмент ХХК	22830015	84.5

8. Дүгнэлт:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хэт богино долгионы FM радио нэвтрүүлэх станцуудын 79.2% нь MNS 4909:2000 “Давтамжийн модуляцтай (FM) хэт богино долгионы (VHF) нэвтрүүлэгч, техникийн шаардлага” стандартын шаардлагыг ханган ажиллаж байна.

Цаашид FM радиогийн үйлчилгээ эрхлэгчид хүлээн авах талд хэмжигдэж буй радио долгионы параметруудыг стандарт хэмжээнд байлгах, сонсогчдод сонсогдож буй дууны сонсголын чанарыг сайжруулахын тулд нэвтрүүлэх хэсгийн тоног төхөөрөмжүүдэд буюу антен, нэвтрүүлэгч, чадлын өсгөгч, холболтын кабель (фидер кабель, аудио кабель)-д техникийн хяналт, үзлэг, үйлчилгээг үргэлжлүүлэн тогтмол хийж байх, мөн студийн дууны холигч пультны түвшинг тогтмол хянаж, стандарт хэмжээнд тохируулж байхыг зөвлөж байна.